



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 03 өдөр

Дугаар A/183

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн A/143 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Блэкстоун Интернэйшнл УЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Блэкстоун Интернэйшнл УЦК" ХХК /П.Мөнхтуяа/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ



000373